



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 11 сарын 20 өдөр

Дугаар А/712

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ийн “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 3.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Эс Жи Эм”ХХК-ний хийж гүйцэтгэсэн Сургуулийн барилгын их засвар /Ховд, Чандмань сум/-н ажлыг хэсэгчилэн хүлээн авах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

| | |
|-----------------------|--|
| Э.Дөлбадрал | -Газрын харилцаа барилга хот байгуулалтын газрын дарга |
| Гишүүд: Д.Нямтулга | - Мэргэжлийн хяналтын газрын Барилгын техникийн хяналтын Улсын байцаагч |
| Н.Цацрал-цэцэг | - Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын Улсын байцаагч |
| З.Өмиртай | -Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга |
| Д.Эрдэнэбат | - Аймгийн Засаг даргын Тамгын газрын дэд бүтэц хариуцсан гэрээт ажилтан |
| Д.Ганзориг | -Чандмань сумын Засаг даргын Тамгын газрын Дарга |
| Ш.Пүрэвдамба | -Чандмань сумын сургуулийн захирал |

- | | |
|-----------------|---|
| Б.Түмэндэмбэрэл | -Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн |
| Б.Бурмаа | -Орон нутгийн өмчийн газрын мэргэжилтэн |
| С.Батдорж | -Аймгийн архивын тасгийн дарга |
| С.Бямбасүрэн | -Барилгын зураг төслийн “Алтайн газрын хүч” ХХК-ний захирал |
| С.Лхагва-Оргил | - “Эс Жи Эм”ХХК-ний захирал |


Нарийн бичгийн
дарга:

Д.Тогтохбаяр

-Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн

2. “Эс Жи Эм” ХХК-ний хийж гүйцэтгэсэн ажлыг захиалагчаас өгөгдсөн ажлын тоо хэмжээтэй тулган, шалгаж өмч бүртгэлд тусгаж хүлээн авах эсэх талаар шийдвэр гарган танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч /Э.Дөлбадрал/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГЫН
ОРЛОГЧ



Т.ЖАРГАЛСАЙХАН